



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 10

Мандалговь

Хөрөнгө акталж худалдах тухай


Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 10,902,843.00 /Арван сая есөн зуун хоёр мянга найман зуун дөчин гурван төгрөг/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 29-30 ДУА улсын дугаартай УАЗ-31512 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 1,000,000.00 /Нэг сая төгрөг/-өөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газар /Үүрэг гүйцэтгэгч С.Нарантунгалаг /-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

0100010